



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
http://www.parliament.mn

2023.04.14 № ТГ-01/492

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Танилцуулга хүргүүлэх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тус тус ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийж, танилцуулгыг хавсралтаар хүргүүлж байна. Үүнд:

- Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаарх санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга (Хавсралт-1);
- Статистикийн тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга (Хавсралт-2).

Хавсралт 1 <sup>13</sup> хуудастай;  
Хавсралт 2 <sup>10</sup> хуудастай.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Л.ӨЛЗИЙСАЙХАН

2023001166



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

**БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БУСАД САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ  
ЗОХИЦУУЛАХ, ХЯНАХТАЙ ХОЛБОГДСОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙН  
ТАЛААРХ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

## Хуудасны дугаар

УДИРТГАЛ	3
НЭГ.БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БУСАД САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАХТАЙ ХОЛБОГДСОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР	4
<i>1.1.Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн салбарыг бодлого, зохицуулалтаар хангах чиг үүргийн хэрэгжилт</i>	4-6
<i>1.2.Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээний бүртгэл, зөвшөөрөл, хянан шалгах чиг үүргийн хэрэгжилт</i>	6-7
<i>1.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт</i>	7-8
<i>1.4.Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиг үүргийн хэрэгжилт</i>	8
ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ, ХҮНИЙ НӨӨЦ, ТӨСВИЙН ТАЛААР	9-10
ГУРАВ.САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР	10-11
ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	11-13

## УДИРТГАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Хороо хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнана.” гэж, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт “Хяналтын зөвлөл үйл ажиллагааныхаа тайланг дараа оны эхний улиралд Улсын Их Хуралд танилцуулна.” гэж тус тус заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, түүний дэргэдэх Хяналтын зөвлөлөөс дараах тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/1294 дүгээр албан бичгээр “Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан”, “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийсэн талаарх тайлан”, “Санхүүгийн салбарын тойм”;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар албан бичгээр “Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан”-г тус тус ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “СЗХ” гэх/, түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийлээ.

Тайланд шинжилгээ хийхдээ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан чиг үүргээ СЗХ болон түүний дэргэдэх Хяналтын зөвлөл үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэхэд дараах агуулгын хүрээнд шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэлээ. Үүнд:

- Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаар;
- Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг, хүний нөөц, төсвийн талаар;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх хяналтын зөвлөлийн чиг үүргийн биелэлтийн талаар зэрэг болно.

## НЭГ.БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БУСАД САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАХТАЙ ХОЛБОГДСОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР

СЗХ нь 2022 онд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд банкны үйл ажиллагаанаас бусад дараах 7 салбар, чиглэлийн 3716 зохицуулалттай этгээд, 2376 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллажээ. Үүнд:

- Үнэт цаасны салбар;
- Даатгалын салбар;
- Банк бус санхүүгийн байгууллага;
- Хадгаламж, зээлийн хоршоо;
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал;
- Үнэт металл, үнэт чулууны арилжаа;
- Виртуал хөрөнгийн салбар.

### **1.1.Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн салбарыг бодлого, зохицуулалтаар хангах чиг үүргийн хэрэгжилт:**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих” гэж заасан.

СЗХ нь санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын Их Хурлаас баталсан 30 гаруй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч ажилласан байна.

Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн салбарын цар хүрээ, үйл ажиллагаа өргөжиж, үүнтэй уялдуулан Монгол Улсын Их Хурлаас сүүлийн 4 жилийн хугацаанд бие даасан 4 хууль баталж, 5 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 2023 оноос СЗХ-ны чиг үүрэгт хамаарах зохицуулалттай салбар, чиглэлийн тоо 4-өөр нэмэгдэж байна. Үүнд:

- Системд нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй арилжих хувьцааг бүртгэх, хянах, зохицуулах;
- Мөнгө зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг бүртгэх, хянах, зохицуулах;
- Уул уурхайн бүтээгдэхүүний бирж, биржийн арилжаанд оролцогчтой холбогдох үйл ажиллагааг хянах, зохицуулах;
- Даатгалын компаниас даатгагчийн баталгаа, батлан даалт гаргах үйл ажиллагааг хянах, зохицуулах.

**Хүснэгт 1.**СЗХ-ны зохицуулалт, чиг үүрэгт хамаарах 2019 оноос хойш шинээр батлагдсан хууль болон нэмэлт, өөрчлөлт

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Нэмэгдсэн салбар, чиг үүрэг
1	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;	2019-2020	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа;
2	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль;	2019-2020	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх үйл ажиллагаа;
3	Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;	2019	Гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд

			санал болгох;
3	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;	2021	Системд нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох;
4	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;	2021	Сэндбокс орчны зохицуулалт;
5	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль;	2021	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа;
6	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;	2022	Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах;
7	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль;	2022	Мөнгө зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа;
8	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль;	2022	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж, биржийн арилжаанд оролцогчтой холбогдох үйл ажиллагаа;
9	Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль.	2022	Даатгагчийн бусад үйл ажиллагаа (даатгалын баталгаа, батлан даалт).

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус нэмэлт, өөрчлөлтөөр банкны системд нөлөө бүхий Хаан банк, ХХБ, Төрийн банк, Хас банк, Голомт банкууд 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн нэг хувьцаа эзэмшигчийн хувьцааны төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хэрэгжүүлэхээр даалгасан.

2022 онд Төрийн банк, Голомт банк хувьцаагаа анхдагч зах зээлд санал болгож, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн. Мөн СЗХ-ны 2022 оны 689 дүгээр тогтоолоор Хаан банкнаас олон нийтэд санал болгож буй үнэт цаасыг бүртгэсэн бөгөөд тус банк нь 2023 оны 04 дүгээр сард хувьцаагаа анхдагч зах зээлд санал болгож, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоолыг баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолыг баталсан. Тогтоолд заасан хуваарийн дагуу нийт 25 төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй санал болгохоор тусгасан.

Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд СЗХ-ны 2022 оны 690 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨҮГ-ын нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх нэмж гаргах хувьцааг бүртгэсэн байна. “Монголын хөрөнгийн бирж” ТӨҮГ нь 2022 оны 12 дугаар сард хувьцаагаа анхдагч зах зээлд санал болгож, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Тогтоолд заасан хуваарийн дагуу 24 төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хувийг олон нийтэд санал болгох ажлыг Монгол Улсын Засгийн газраас 2023 онд зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь


хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох” гэж заасан.

Энэ хүрээнд СЗХ-оос баталсан 119 дүрэм, журам, заавар, аргачлал тус салбарт мөрдөгдөж байгаагаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 64 акт байна.

Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт заасны дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зохицуулалттай.

СЗХ нь 2022 онд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 12 актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн улсын нэгдсэн санд бүртгүүлсэн бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар СЗХ-оос батлан мөрдөгдөж байгаа хэм хэмжээ тогтоосон нийт 64 актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн улсын нэгдсэн санд бүртгүүлж дууссан байна.

**Зураг 1.**СЗХ-оос баталсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон нийт журмыг салбараар ангилсан байдал



СЗХ-оос батлан мөрдөгдөж байгаа бусад 55 акт нь захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлэх шаардлагагүй буюу заавал мөрдөх шинжийг агуулаагүй, дотогш чиглэсэн, эсхүл нэг удаагийн шинжтэй харилцаанд хамаарч байна.

СЗХ нь 2022 онд нийт 25 удаа хуралдаж салбарын асуудлыг хэлэлцэн 739 тогтоол гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь цар тахлын дараах санхүүгийн зах зээлийн идэвхжил болон банкны үйл ажиллагаанаас бусад зохицуулалттай салбарын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **1.2.Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээний бүртгэл, зөвшөөрөл, хянан шалгах чиг үүргийн хэрэгжилт:**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “санхүүгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих” гэж, 6.1.4-т “зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагааг шалгах” гэж тус тус заасан.

Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд СЗХ нь газар дээрх шалгалтыг 371 удаа зохион байгуулж, 55 шийтгэлийн хуудас үйлдэж, 339.0 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна. Мөн зайнаас тавих хяналт шалгалтын хүрээнд 12,495 тайлан, мэдээллийг цахимаар хүлээн авч хянан баталгаажуулжээ.

СЗХ-нд 2022 онд давхардсан тоогоор 1620 хуулийн этгээдээс тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлтийг цахимаар ирүүлснээс баримт бичгийн бүрдэл хангаагүй 300 хүсэлтийг буцааж, шаардлага хангасан 1320 хүсэлтийг хүлээн авч, холбогдох бүртгэл, зөвшөөрлийг олгосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүртгэл, зөвшөөрлийн тоо 72 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

СЗХ нь газар дээрх хяналт шалгалт болон зайнаас тавих хяналтын хэлбэрийг хослуулан хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлж байгаа хэдий ч зохицуулалттай салбарын тоо, чиг үүрэг нэмэгдсэнтэй холбогдуулан нэг хянан шалгагчид ногдох хуулийн этгээдийн тоо 80-120 болсноор хянан шалгагч нарын ажлын ачаалал нэмэгдсэн байна.

Өнгөрсөн хугацаанд виртуал хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд СЗХ-оос хяналт тавих эрх зүйн орчин бүрдээгүй буюу зохицуулалтгүй салбар байсан. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг баталснаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийг СЗХ-оос бүртгэж, хяналт тавих эрх зүйн орчин бүрдсэн.

Хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд 2022 онд виртуал хөрөнгийн салбарт үйлчилгээ үзүүлэгч 11 хуулийн этгээдийг бүртгэж, 15 хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоосон бөгөөд хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд шинээр гаргасан койн, токен байхгүй байна.

Мөн СЗХ-оос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд мөрдөх 8 хэм хэмжээ тогтоосон актыг боловсруулж Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн баталжээ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих хүрээнд блокчэйн гүйлгээний хяналтын “Chainalysis” программыг ашиглах нөхцөл бүрдсэн бөгөөд энэхүү программ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад хэвийн бус гүйлгээг автоматаар хянах боломжтой юм.

### **1.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт:**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д “зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээдийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих” гэж заасан.

СЗХ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2021-2026 үндэсний хөтөлбөр”-ийг батлуулжээ.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах зорилгоор виртуал хөрөнгийн салбарт үндэсний хэмжээнд үнэлгээ хийж, холбогдох журам, зааврыг боловсруулж батлуулсан бөгөөд тус чиглэлийн хүрээнд газар дээрх хяналт шалгалтыг 243 удаа зохион байгуулсан байна.

Мөн компанийн засаглал, комплайнсын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталж, тогтоолын хавсралтаар “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн загвар”-ыг баталсан. Тус кодексийн дагуу ТУЗ нь



кодексийн хэрэгжилтийг арилжаа эрхлэгч компанид тайлагнах, мөн жилийн үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд мэдээлэх үүрэгтэй болсон бөгөөд хэрэв кодексийн хэрэгжилт хангалтгүй гэж үзвэл тухайн үнэт цаасны ангилал буурах, мөн хөрөнгө оруулагчид санхүүгийн тоон үзүүлэлтээс гадна компанийн засаглалыг үнэлж шийдвэрээ гаргах нөхцөл бүрджээ.

2022 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх, санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага ФАТФ-аас гаргасан техникийн 40 зөвлөмжөөс Монгол Улс 39-ийг “бүрэн хэрэгжсэн” болон “дийлэнх хэрэгжсэн” үнэлгээ авснаар ФАТФ-ын гишүүн бус орнуудаас “Зөвлөмж 15”-ын үнэлгээг ахиулсан анхны улс болсон байна.

#### **1.4.Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиг үүргийн хэрэгжилт:**

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд СЗХ нь 2022 онд нийт 18 шүүхийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцсон бөгөөд нийт хэрэг маргааны 80 орчим хувийг захиргааны хэрэг эзэлж байна.

СЗХ-нд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, иргэн, хуулийн этгээдээс нийт 599 өргөдөл, гомдол ирүүлснээс 40 хувийг даатгалын салбартай холбоотой өргөдөл, гомдол эзэлсэн байна.

Нийт өргөдөл, гомдлоос зөрчлийн шинжтэй 70 өргөдөл, мэдээлэл бүртгэгдэж 276.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Мөн хувьцаа зөвшөөрөлгүй худалдсантай холбоотой гомдол гаргасан 2 иргэнд 51 сая төгрөгийг олгуулсан бол, даатгалтай холбоотой 51 иргэн, хуулийн этгээдэд 541.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар шийдвэрлэснээс 174.4 сая төгрөгийг нөхөн олгуулсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т “иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах” гэж заасан.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд 34 удаагийн сургалт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр 56 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулжээ. Мөн монгол хэл дээр бэлтгэсэн 219, англи хэлээр 94 мэдээ, мэдээллийг бэлтгэж өөрийн цахим хуудас, олон нийтийн сүлжээ болон ikop.mn цахим хуудсанд тухай бүр байршуулжээ.

СЗХ-ны үйл ажиллагаанд хамаарах мэдээллийн холбоосыг [www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn) цахим хуудсанд байршуулж эхэлсэн нь санхүүгийн мэдлэг, мэдээллийг нэгдсэн нэг сувгаар олон нийтэд хүргэх нөхцөл бүрдсэн байна.

Хэдийгээр иргэдийн санхүүгийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх хүрээнд тодорхой ажлууд хийгдэж байгаа хэдий ч санхүүгийн залилан, луйврын схем, санхүүгийн пирамид гэх мэт эдийн засгийн гэмт хэргийн тоо болон хохирлын хэмжээ төдийлөн буурахгүй байна. Цаашид иргэдийн эрх ашгийг хамгаалах, эдийн засгийн болон санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд холбогдох санхүүгийн байгууллагаас гадна төрийн бусад байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулах, мөн орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

## ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ, ХҮНИЙ НӨӨЦ, ТӨСВИЙН ТАЛААР

2005 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар СЗХ-ны бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээг хуульчлан тогтоосон байдаг. Анх СЗХ нь үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын салбарын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй байгуулагдаж байсан.

Банкны үйл ажиллагаанаас бусад зохицуулалттай салбар, чиглэлийн тоо 2005 онд 4, 2022 онд 7, 2023 оноос 11 болж нэмэгдэж байна. Салбарын тоо нэмэгдсэнтэй холбогдуулан зохицуулалттай этгээдийн тоо сүүлийн 4 жилийн байдлаар 58 орчим хувиар өссөн.

СЗХ нь 2022 онд нийт 162 албан хаагчтайгаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан бөгөөд чиг үүрэг нэмэгдэж байгаатай холбогдуулан ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор орон тоогоо нэмэгдүүлэх саналыг төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлж байсан боловч төсвийн хэмнэлтийн бодлоготой холбогдуулан дэмжигдээгүй байна. Иймд шинээр нэмэгдсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд бусад нэгжээс албан хаагчдыг шилжүүлэн ажиллуулах, ажил хавсран гүйцэтгүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллажээ.

Мөн СЗХ нь улсын хэмжээнд хяналт, зохицуулалт хийх чиг үүрэгтэй байдаг тул СЗХ-ны үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх санхүү, хүний нөөц, зохион байгуулалтын арга хэмжээ авах бүрэн эрхийг Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ээр олгосон байдаг.

Гэвч санхүү, хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Сангийн сайд, СЗХ-ны даргын 2007 оны “Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай” 330/108 дугаар хамтарсан тушаалын хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга болон тус хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн СЗХ-ны орон нутгийн төлөөллийн чиг үүргийг **хавсран гүйцэтгэж байна**. Өөрөөр хэлбэл, СЗХ-ны **орон тооны** салбар, төлөөлөгч орон нутагт байхгүй байна.

**Байгууллагын төсөв:** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу СЗХ-ны санхүүжилт нь улсын төсөв болон зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс бүрддэг.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар СЗХ-ны багцад 7,494.3 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт батлагдсан төсвийн 64 хувийг улсын төсвийн санхүүжилтийн орлого, 36 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалтын үйлчилгээний хураамжийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр төлөвлөснөөс орлогын гүйцэтгэл 60:40-ийн харьцаатай биелсэн байна.

Нийт орлогын гүйцэтгэл 7,492.8 сая төгрөг бөгөөд нийт зардалд 7,494.3 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 6,309.9 сая төгрөг зарцуулж 1,184.4 сая төгрөг хэмнэсэн байна.

Үндсэн үйл ажиллагаанаас нийт 3,102.6 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд нийт орлогыг салбар, чиглэлээр нь ангилбал:

- ББСБ-ын салбар 1,206.0 сая төгрөг буюу 39.0 хувь;
- Даатгалын салбар 774.0 сая төгрөг буюу 25.0 хувь;
- Үнэт цаасны салбар 814.0 сая төгрөг буюу 26.2 хувь;
- Хадгаламж, зээлийн хоршооны салбар 36.5 сая төгрөг буюу 1.2 хувь;

- Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн байгууллага 102.9 сая төгрөг буюу 3.3 хувь;
- Виртуал хөрөнгө 85.8 сая төгрөг буюу 2.7 хувь;
- Бүртгэл, зөвшөөрөл 82.5 сая төгрөг буюу 2.6 хувийг тус тус эзэлж байна.

Улсын төсөвт 3,352.7 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 308.1 сая төгрөгийн торгуулийн орлогыг тус тус төвлөрүүлж ажилласан байна.

Нийт зардлын 62.5 хувийг цалин хөлс болон нэмэгдэл хөлс, 20.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 9.6 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төсөх шимтгэл, 3.9 хувийг урсгал шилжүүлэг, 1.6 хувийг хөрөнгийн зардал, 1.9 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

## **ГУРАВ.САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий **орон тооны бус зөвлөл** ажиллана” гэж заасан.

Мөн хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Хяналтын зөвлөл нь дарга болон 4 гишүүнээс бүрдэх бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаатай томилж, чөлөөлдөг. Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас бүрэн эрхийн хугацаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд хянан үзвэл, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2016 онд дуусгавар болсон байна.

Хяналт зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон хэдий ч өнгөрсөн хугацаанд Хяналтын зөвлөлийн дарга Р.Ренчинбазар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ирсэн байна.

**Хүснэгт 2.**СЗХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацааны талаарх мэдээлэл

Д/д	Албан тушаал	Овог, нэр	Томилогдсон огноо, дугаар	Бүрэн эрхийн хугацаа дуусах огноо
1.	Хяналтын зөвлөлийн дарга	Р.Ринчинбазар	2013.12.26 №72	2016.12.26-нд бүрэн эрхийн хугацаа дууссан
2.	Зөвлөлийн гишүүн	Б.Амарсанаа		
3.	Зөвлөлийн гишүүн	Д.Цэрэнбадам		
4.	Зөвлөлийн гишүүн	А.Өнөржаргал		
5.	Зөвлөлийн гишүүн	Ж.Эрдэнэбилэг		

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны ажиллах журам”-ын 1.2 дахь хэсэгт заасны дагуу СЗХ-оос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, СЗХ-ны үйл ажиллагаанд хяналт тавих, СЗХ-ны үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитын гаргасан, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.

Хяналтын зөвлөлийн 2022 оны тайлангаас үзэхэд СЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой 5 албан бичиг хүлээн авч, 17 албан бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Мөн иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн СЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой 8 гомдол хүлээн авснаас 2 гомдлыг Хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй буюу үндэслэл хангалтгүй гэж үзэж албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн байна.

Харин үлдсэн 6 гомдол, хүсэлтийг Монгол Улсын Их Хурлын 2006 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны ажиллах журам”-ын 4.9-д заасны дагуу Хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх зохицуулалттай хэдий ч Хяналтын зөвлөлийн 4 гишүүнийг томилоогүй тул гомдлыг шийдвэрлэх боломжгүй байгаа талаар албан бичгээр хариу мэдэгдсэн байна.

Түүнчлэн СЗХ-ны үйл ажиллагаанд хяналт тавих, СЗХ-ны үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитын гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийн талаар тайланд дурдаагүй байна. Өөрөөр хэлбэл, Хяналтын зөвлөлийн ажиллах нөхцөл бүрдээгүйгээс хуульд заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

## **ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас СЗХ болон түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийлээ.

### **Дүгнэлт**

1. Монгол Улсын Их Хурлаас 2019 оноос хойш СЗХ-ны чиг үүрэгт хамаарах бие даасан 4 хууль баталж, 5 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 2022 онд банкны үйл ажиллагаанаас бусад зохицуулалттай салбар, чиглэлийн тоо 7 байсныг 2023 оноос 11 болгож нэмэгдүүлсэн байна. Салбар, чиглэлийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан зохицуулалттай этгээдийн тоо сүүлийн 4 жилийн байдлаар 58 хувиар өсжээ;
2. 2022 онд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр СЗХ-оос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх зүйн орчин бүрдэж, тус салбарт үйлчилгээ үзүүлэгч 11 хуулийн этгээдийг бүртгэж, 15 хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоосон байна;
3. СЗХ нь шинээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2022 онд нийт 12 хэм хэмжээ тогтоосон актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна. Үүнээс 6 хэм хэмжээ тогтоосон акт нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд мөрдөгдөх акт байна;
4. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дагуу 2022 онд Төрийн банк, Голомт банк хувьцаагаа анхдагч зах зээлд санал болгож, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн. СЗХ-оос хуульд заасан чиг үүргийн дагуу эдгээр банкуудын нийтэд санал болгосон хувьцааны бүртгэлийг холбогдох журмын дагуу бүртгэсэн байна;
5. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу нийт 25 төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй санал болгохоор тогтсон. СЗХ-ны 2022 оны 690 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨҮГ-ын нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх нэмж гаргах хувьцааг бүртгэсэн байна;

6. 2022 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх, санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага ФАТФ-аас гаргасан техникийн 40 зөвлөмжөөс Монгол Улс 39-ийг “бүрэн хэрэгжсэн” болон “дийлэнх хэрэгжсэн” үнэлгээ авснаар ФАТФ-ын гишүүн бус орнуудаас “Зөвлөмж 15”-ын үнэлгээг ахиулсан анхны улс болсон байна;
7. СЗХ нь 2022 онд нийт 25 удаа хуралдаж салбарын асуудлыг хэлэлцэн 739 тогтоол гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн үзүүлэлттэй байна;
8. СЗХ нь бүртгэл, зөвшөөрөл олгохтой холбоотой 1320 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 72 хувиар өссөн үзүүлэлттэй байна;
9. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, иргэн, хуулийн этгээдээс СЗХ-нд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын 40 хувийг даатгалын салбартай холбоотой өргөдөл, гомдол эзэлсэн байна;
10. Зохицуулалттай салбар, чиг үүргийн тоо өссөн нь СЗХ-ны нэгжүүдийн ажлын ачаалал нэмэгдэх, мөн зохицуулалттай шинэ салбар, чиглэлд мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээ шаардлага үүсэх нөхцөл бүрдүүлсэн байна;
11. Орон нутагт Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга болон тус хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн СЗХ-ны орон нутгийн төлөөллийн чиг үүргийг **хавсран гүйцэтгэж** байгаа нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих нөхцөлийг бүрдүүлээгүй байна;
12. СЗХ-ны багцад 7,494.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,184.4 сая төгрөг буюу нийт төсвийн 16.0 хувийг хэмнэсэн байна. Тухайлбал, сул орон тооны цалингийн зардлаас 595.5 сая төгрөгийг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 541.0 сая төгрөгийг хэмнэсэн байна;
13. СЗХ-оос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, СЗХ-ны үйл ажиллагаанд хяналт тавих, СЗХ-ны үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитын гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн бүрэн бус байгаа нь тус зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр байна.

### **Зөвлөмж**

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд тавих СЗХ-ны хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;
3. Чиг үүрэг нэмэгдэж байгаатай холбогдуулан СЗХ-ны зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэгт шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шаардлагатай тохиолдолд мэдээллийн технологийн шийдлийг ашиглах;

4. СЗХ-нд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын 40 хувийг даатгалын салбар эзэлж байгааг судлан үзэж, шалтгаан нөхцөлийг тогтоож, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарах;
5. Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан байгааг анхаарч, СЗХ-ны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авах.

---000---